



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/184

Чингис хот

Хөл хорио тогтоож урьдчилан сэргийлэх
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Аймгийн Онцгой комиссын 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн, Дэлгэрхаан сумдад Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын батлагдсан тохиолдлын голомтын эх үүсвэр тодорхойгүй, тархалтын хүрээ нэмэгдэж байгаатай холбогдуулан дээрх 2 сумын хатуу хөл хориог 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 00:00 цагаас халдварын голомтыг тогтоон цар тахлын хүрээг хумих хүртэлх хугацаанд тодорхойгүй хугацаагаар сунгаж, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Хатуу хөл хорио тогтоосон хугацаанд иргэдэд түлш, ус, нэн шаардлагатай хүнс, ахуйн хэрэглээний бараа, эм, эмийн бүтээгдэхүүнийг хүргэлтээр хангах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хүргэлтийн үйлчилгээний ажилчдад халдвар хамгааллын дэглэм оношилгоо шинжилгээнд хамруулж ажиллахыг дээрх сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Голомтын бүсэд ажиллаж байгаа эмч ажилчдын халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/-г тус тус үүрэг болгосугай.

4. Шуурхай штаб болон хязгаарлалтгүй ажиллах тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор ажилтнуудыг шаардлагатай суурин компьютер, нөүтбүүкээр ханган гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011853